



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 4/133

Номгон

Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн
салбар зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 21 дүгээр зүйлийн 21.7.12, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны “Салбар зөвлөл байгуулах тухай” 03 дугаар тогтоолоор баталсан “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.3, 1.4, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн” 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Дэд дарга:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Төрийн албаны салбар зөвлөлийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Төрийн архивын тасгийн дарга

Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга

Насан туршийн суралцахуйн төвийн захирал

Аймгийн Нийтийн номын сангийн захирал

Бодлогын асуудал хариуцсан нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн

Боловсрол хариуцсан мэргэжилтэн

625010397


Арга зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга:

Аймгийн Боловсролын газрын Монгол хэл, уран зохиолын боловсрол хариуцсан мэргэжилтэн

3.Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн аймгийн салбар зөвлөлийн дарга гишүүдэд, “Хэлний бодлогын салбар зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, ажлын тайланг хагас бүтэн жилээр Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлж байхыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-т даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/83 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

